



ШИНЖЭЭЧИЙН ТАЙЛАН

Байгууллагын нэр: МАРГАД ДЭЭД СУРГУУЛЬ

Хөтөлбөрийн нэр: БАГШ, СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ

Индекс: D011201

Шинжээчийн баг:

Ахлагч: ЧҮ.БАЙГАЛМАА
Гишүүд: Б.ТҮВШИНЖАРГАЛ
Б. НАРАНЧИМЭГ

2022.06.12.

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

I. ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ҮЙЛ ЯВЦ, ТӨЛӨВЛӨЛТ

Сургуулийн нэр /Монгол,	МАРГАД ДЭЭД СУРГУУЛЬ MARGAD UNIVERSITY	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАГШ PRE-SCHOOL TEACHER	
Индекс	D011201	
Шинжээчид	ЧҮ. Байгалмаа /Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн багш, доктор/ Б.Түвшинжаргал /Нийслэлийн боловсролын газрын Сургуулийн өмнөх боловсрол хариуцсан мэргэжилтэн/ Б. Наранчимэг /Нийслэлийн ерөнхий боловсролын 45 дугаар сургуулийн захирал/	
БМИУЗ-ийн Мэргэжилтэн	Г.Даваажаргал /доктор, дэд профессор/	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд (Мэргэжилтний гаргасан хуваарийн дагуу бичнэ)
	2022.05.11	Шинжээчдэд өөрийн үнэлгээний тайланг хүлээлгэн өгнө.
	2022.05.17.	Шинжээчид урьдчилсан үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	2022.05.19	Мэргэжилтэн сургууль дээр цахимаар шинжээч ажиллах бэлтгэлийг хангуулна.
	2022.05.20-21	Шинжээчид сургуульд очиж ажиллана.
	2022.05.30	Шинжээчид үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	2022.05.30	Шинжээчдийн үнэлгээний тайланг сургуульд илгээж санал авна.
	2022.05.31	Сургууль үнэлгээний тайлантай танилцаж, тайлбар, нотлох баримтыг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	2022.05.31	Шинжээчид үнэлгээний тайланг эцэслэнэ.

Шалгуур шаардлага /журам/	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 08 тоот тогтоолоор баталсан “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”-ын “Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур
---------------------------	--

II. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ТАНИЛЦУУЛГА

Маргад дээд сургууль нь 2014 оноос сургуулийн өмнөх боловсролын багш хөтөлбөр хэрэгжүүлж, Дидактикийн тэнхим хариуцан ажиллаж байна. Баруун хангайн бүсийн Архангай, Завхан, Булган, Хөвсгөл, Сэлэнгэ, Өмнөговь, Увс, Баян-Өлгий, Дундговь, Дорноговь болон Говийн бүсийн аймгаас элсэлт авдаг. Үндсэн сургалтын зэрэгцээгээр Хангайн бүсийн хэмжээнд “Цэцэрлэгийн туслах багш бэлтгэх” сургалт зохион байгуулж 13 удаа өвөл, хаврын төгсөлт хийжээ. Хөтөлбөр нээгдсэн цагаас өнөөг хүртэл, үндсэн болон хөрвөх ангиар сургуулийн өмнөх боловсролын байгууллагад нийт 403 багшийг бэлтгэсэн. Мөн хангайн бүсийн багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалт, дипломын дараах сургалтыг зохион байгуулж, ажил олгогчид, төгсгөгчдийн сэтгэл ханамж сайн. Төгсөгчдийн 12.1% нь ахисан түвшний сургалтад хамрагдаж магистрын зэрэг хамгаалсан.

2014-2018 онд БНСУ-ын Чежү Халла Их сургуультай багш солилцооны хөтөлбөр хэрэгжүүлсэн. Бага ангийн болон цэцэрлэгийн багш бэлтгэх дадлагын хөтөлбөрийг ОХУ-ын Алтайн багшийн их сургуультай хамтран хэрэгжүүлдэг. Сургуулийн өмнөх боловсрол мэргэжлээр суралцагч оюутны дадлагын бааз Орхон аймгийн 34 дүгээр цэцэрлэг болон сэтгэл зүйн алба, байгалийн ухааны лабораторид сургалтаа зохион байгуулдаг.

Монгол Улсыг хөгжүүлэх “Алсын хараа-2050” төлөвлөгөөнд заасны дагуу орон нутагт Орхон аймгийн бүх цэцэрлэгүүдийг ээлжийн багшаар хангах зорилтын хүрээнд ээлжийн багшийн судалгааг гаргасан. Түүний дагуу ээлжийн багшийг бэлтгэх ажлыг тухайн хөтөлбөрөөр зуны түргэвчилсэн, хөрвөх ангиар багш бэлтгэж байна.

III. ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ

ШАЛГУУР 1. ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

- Дээд боловсролын бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага, хэрэглэгч ба оролцогч талуудын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн хөтөлбөрийг иж бүрэн боловсруулж, хөтөлбөрийн хороогоор хэлэлцүүлэн баталж мөрддөг.

- Бакалаврын сургалтын мэдлэг, чадвар, хандлага төлөвшүүлэх сургалт, үйл ажиллагааны ажлууд нь хөтөлбөрт дийлэнх хувийг эзлэх ба тэдгээрийн төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ, чанарын баталгаажуулалт, үр дүнг хүлээн зөвшөөрөх арга барил нь хувь хүний болон мэргэжлийн хөгжлийг дэмжсэн, чөлөөт сонголт бүхий олон хувилбараар хэрэгжихээр төлөвлөсөн.
- Сургалтын хөтөлбөрт 2015, 2019, 2020 онуудад 3 удаа сайжруулалт хийсэн.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага: Орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

Анхаарах асуудал: Дидактикийн хөтөлбөрийн агуулгын уялдаа холбоог сайжруулах

Зөвлөмж: Дидактикийн хөтөлбөрийн агуулгыг интеграцчилах боломжийг судлан хэрэгжүүлэх

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- STEEP шинжилгээ
- Хөдөлмөрийн зах зээлийн барометрийн судалгаа (мэргэжилтний эрэлт хэрэгцээний судалгаа, бага насны хүүхдийн цэцэрлэгт хамрагдалтын тоон өсөлт)
- Хөтөлбөрийн талаарх суралцагчдын үнэлгээ (сүүлийн 3 жилээр)
- Оролцогч талуудын үнэлгээ, судалгаанууд
- Хөтөлбөрийн төлөвлөлт, гүйцэтгэл /PDCA/
- Сургуулийн өмнөх насны боловсролын багш хөтөлбөрөөр төгссөн төгсөгчдийн судалгаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Нийгмийн эрэлт хэрэгцээ бүс нутгийн хэрэгцээ
- Ээлжийн багшийн эрэлтийн судалгаанд нийцсэн.

Зөвлөмж: “Сургуулийн өмнөх насны боловсролын багш”-д тавигдаж буй нийгмийн шаардлагад нийцүүлэн улам боловсронгуй болгох

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн агуулга нь суралцахуйн зорилтот үр дүнд чиглэсэн, онол практикийг зохистой хослуулан, логик дэс дараалалтай, давхардалгүй боловсруулж, заавал болон сонгон суралцах агуулга, сургалтын хэлбэрийг зохистой тогтоосон.
- Маргад дээд сургуулийн сургалтын журам
- Хөтөлбөрт орсон хичээл тус бүрийн иж бүрэн файлууд
- Сургуулийн эрдмийн зөвлөл, хөтөлбөрийн хорооны хурлын тэмдэглэлүүд
- Сургалтын хөтөлбөр

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Агуулгаа дадлагаар туршиж хэрэгжүүлж сайжруулдаг.
- Орон нутгийн мэргэжлийн сургалтын байгууллагуудын үнэлгээ, сэтгэл ханамж өндөр.
- Минор хөтөлбөрийг хэрэгжүүлж ирсэн (хөгжмийн багш, биеийн тамирын багш)

Анхаарах асуудал: Онолын агуулгын уялдаа холбоог анхаарах

Зөвлөмж: Агуулга хоорондын залгамж холбоо хэрэгцээ шаардлагын судалгааг гаргах

I шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан.

ШАЛГУУР 2. СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

- Олон улсын боловсролын талаарх үзэл баримтлал, чиг хандлагын судалгаа
- Ажил олгогч, төгсөгч суралцагчид, олон нийтийн хэрэгцээ шаардлагын судалгаа баримт
- (PLO) - Хөтөлбөрөөр оюутны хүрэх үр дүнг урьдчилан тодорхойлсон.
- Сургалтын үр дүнгийн үнэлгээ
- Сургалтын хөтөлбөрийг гарын авлага болгон оюутанд хүргэдэг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага

- Хөтөлбөрийн агуулга нь суралцагчдад СӨНХ-ийн хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцэн ажиллах мэдлэг, дадал чадвар эзэмшихэд чиглэсэн.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын болон эцсийн үнэлгээг багш өөрөө хийж, түүний мөрөөр ажиллах
- Мэргэжлийн багш нарын хамтын ажиллагааг сайжруулах

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- Эрдмийн зөвлөлийн 2019 оны 3 сарын 15-ны өдрийн хурлаар хөтөлбөрүүдийг хэлэлцэж баталсан протокол
- Багш, сургуулийн өмнөх насны боловсролын мэргэжлийн хичээлийн хөтөлбөрүүд
- Оюутны бие даасан ажлын удирдамжууд
- Хөтөлбөрийн өөрчлөлтийн матриц
- Төгсөгчийн загварын SWOT шинжилгээ
- Хөтөлбөрийн TOWS шинжилгээ
- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа
- Хичээлийн агуулгыг аудио, видео, цахим хэлэлцүүлэг зэрэг хэлбэрээр боловсруулж Moodle болон Zoom програмаар оюутнуудад хүргэсэн судалгаа
- Цахим сан, хэрэглэгдэхүүний бүрдэл, хичээлд бэлтгэх орчин нөхцөл

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Цахим сургалтын сантай
- Оюутан багш нарт зориулсан гарын авлагатай.

Анхаарах асуудал:

- Сургалтын төлөвлөгөөний цагийн хуваарилалтад анхаарах

Зөвлөмж:

- Интеграцчилсан сургалтын арга зүйгээс хэрэгжүүлэх

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Хичээлийн агуулгын тогтолцооны бүрэлдэхүүн /сэдэв, модуль, бүлэг сэдвийн хүрээнд/ хэсгээр эзэмшсэн мэдлэг, чадварыг үнэлдэг
- Мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрийн хүлээгдэж буй үр дүнг үнэлэх буюу багш бэлтгэх хөтөлбөрөөр эзэмшсэн мэдлэг, чадварыг үнэлэх нэгдсэн үнэлгээ

- 30 кредит тутамд гарааны багшийн мэдлэг, чадвар хандлагыг үнэлэх ба прогресс тестийн системээр ахицыг үнэлдэг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Ажил олгогч нарын үнэлгээг дадлагын үнэлгээнд тооцдог.

Зөвлөмж:

- Хөрвөх ангиар суралцах оюутны дүйцүүлэх хичээлийн агуулгын давхцал, ялгааг сайтар тооцож, дүйцүүлэх

II шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

ШАЛГУУР 3. ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ОРЧИН, НӨӨЦ

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

- Өөрийн өмчлөлийн газар, үл хөдлөх хөрөнгөтэй бөгөөд сургуулийг хотхоноор хөгжүүлэх зорилт тавин ажиллаж байгаа ба “А” корпус сургалтын үйл ажиллагааг 2 давхар 1800 м², талбай бүхий хичээлийн байр, “Б” 65 корпус оюутны дотуур байр, цайны газар, оюутны номын сан бүхий 4 давхар 960 м барилгад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд, ажлын байрны орчин, эрүүл ахуйн шаардлага /MNS 4990-2015 / стандарт нөхцөлийг хангаж, үйл ажиллагаагаа явуулж байна.
- Урлагийн заал: сургуулийн подвалын хэсгийг засварлан гэрэлтүүлэг, хувцас солих өрөө бүхий урлаг заалийг 25 сая төгрөгийн санхүүжилт хийж, 2015 онд ашиглалтанд оруулсан.
- Сургуулийн “Б” корпус ашиглалтад орсоноор 60 оюутны багтаамжтай 15 өрөө, оюутны дундын гал тогооны 2 өрөө, ариун цэврийн 2 өрөө, оюутны санаачлагын төслөөр байгуулагдсан оюутны номын сан бүхий дотуур байрыг барьж байгуулсан.
- Сургуулийн цайны газар багш, ажилчид, оюутнуудад үйлчлэх төдийгүй бага ангийн сурагчдын “Үдийн цай” хөтөлбөрийг хэрэгжүүлж, эрүүл ахуйн шаардлага хангасан, амт чанар сайтай хоолоор үйлчилж байна.
- Сургуулийн хэрэглээний усны зардлыг багасгах зорилгоор өөрийн усны эх үүсвэрийг бий болгох гүний худгийн хайгуул судалгаа хийж, худаг барих ажилд 18 орчим сая төгрөг зарцуулан 2017 онд ашиглалтад оруулсан
- Архивын мэдээлэл сүлжээний программ хангамжийг ашиглалтанд оруулахад хүчин чадал бүхий компьютер, тоног төхөөрөмж авч ажиллуулахад 8 сая төгрөг зарцуулсан
- Номын сан, спорт заалны зураг төслийн ажил 18 сая төгрөгөөр хийгдсэн ба барилгын ажлыг төлөвлөсөн.
- СӨБ-ийн сургалтын 201, 207 танхимд 2014 онд сургалтын орчин бүрдүүлсэн.

- 10 кабинет, 4 лаборатори, 3 дадлагын баазын үйл ажиллагаа тогтмолжсан
- Мэдээлэл технологийн кабинетыг 15 сая төгрөгөөр шинэчлэн байгуулсан.
- Сургуулийн урсгал засварт жил бүр тодорхой хөрөнгийг төсөвлөн зарцуулдаг зэрэг сургуулийн орчны тохижилт, эд хөрөнгө, тоног төхөөрөмж, хөрөнгө оруулалтын асуудлыг сургууль өөрийн орлогоор бүрэн санхүүжүүлж байна.
- Сургуулийн ерөнхий төлөвлөгөөний дагуу гадна талбайн зам, зогсоол, 68 усны хаялгын ажлыг 60 гаруй сая төгрөгөөр хийж 2018 онд бүрэн ашиглалтанд оруулсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хотхон байдлаар тохижилт хийгдэж байгаа.

Анхаарах асуудал:

- Өөрийн эзэмшлийн спорт заалгүй, зураг төсөл нь хийгдсэн.

Зөвлөмж:

- Спорт залны барилгын ажлаа яаравчлан, өөрийн залтай болох

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн онцлогоос хамааран жил бүр зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл жилд дунджаар 1580,000 төгрөгөөр материаллаг нөөцийг бүрдүүлдэг.
- Сүүлийн жилүүдэд ашиглаж байгаа туршилт судалгааны программ хангамжууд сургуулийн орчинд оюутан ашиглахад нээлттэй.
- Биет болон хэвлэмэл хэрэглэгдэхүүн сургалтын кабинетад бүрэн хангагдсан байна.
- Контент хичээлийн загварыг гаргаж нөөц бүрдүүлсэн байна.
- Мэргэжлийн хичээлүүдийг <http://learning.margadedu.com> системд оруулж байна.
- Сургуулийн цахим сургалтын систем нь сургалт удирдлагын MOODLE систем дээр хийгдсэн бөгөөд хэрэглэхэд хялбар, энгийн ойлгомжтой.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хүүхдийн сэтгэн бодох үйл ажиллагааг хөгжүүлэх Монгол ардын оньсон, хөлөгт эвлүүлдэг тоглоом үйлдвэрлэн цэцэрлэг, сургуулиудад нийлүүлдэг. Оюутнууд дадлагын хугацаанд биет үзүүлэн дадлагын хугацаанд хийж сургуульдаа бэлэглэдэг.

Анхаарах асуудал:

- Биет болон хэвлэмэл хэрэглэгдэхүүнээ товъёогжуулаагүй.

Зөвлөмж:

- Сургалтын хэрэглэгдэхүүнийг нэр, төрлөөр нь бүртгэлжүүлэх

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургуулийн номын сан 2004 онд ашиглалтад орсон. 120,96м² талбайтай, суудлын тоо 60, 362 байнгын уншигчтай, 1 номын санчтай, нийт номын фонд нь 19 нэр төрлийн 196 717 970 үнэ бүхий 22814 ширхэг номтой.
- Номын сан үүлэн технологид суурилсан lib4u.net/pro/ програмыг ашигладаг.
- СӨБ мэргэжлийн багш, оюутнуудаас судалгаа авч хичээлийн үндсэн сурах бичиг, гарын авлагаар номын сангийн фондыг баяжуулж, сургалтдаа ашигладаг байна.
- Номын сангийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч, алдаа дутагдлыг засаж залруулах арга замыг тодорхойлох, үйлчилгээг сайжруулах зорилгоор суралцагч, оюутны сэтгэл ханамжийн судалгааг жилд 1 удаа авч дүгнэдэг.
- Сургуулийн захиргаа, санхүүгээс номын санд зарцуулах төсвийг тогтвортой хадгалах, цаашид өсгөх бодлого барьж ажиллаж байна.
- Сүүлийн 5 жилд 216,277,950 төгрөг номын баяжилт хийж, нэг оюутанд ногдох номын тоо 30 болж өссөн.
- Электрон номын каталогт 7382 номтой.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Номын сангийн үүлэн технологийн программ ашиглалт

Зөвлөмж:

- Номын сангийн баяжилтыг хөтөлбөр тус бүрээр нь гаргах

Ш шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

ШАЛГУУР 4. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж хөдөлмөрлөх, суралцах таатай орчин бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежмент хэрэгждэг.
- Хөтөлбөрийн хороог сургуулийн захирлын 2018 оны 10-р сарын 10-ны өдрийн 65 тоот тушаалаар байгуулан 2014 оны 6-р сарын 13-ны өдрийн 12 тоот тушаалаар “Хөтөлбөрийн хорооны ажиллах журам” “Хөтөлбөрийн хорооны хийх ажлын үндсэн чиглэл” зэргийг батлан гаргасан байна.

- БМИҮЗ-ийн 08 тоот тушаалаар батлагдсан “Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур, шаардлага” болон “Сургууль хөгжүүлэх стратеги төлөвлөгөө 2018-2022” зэрэг баримт бичгийг үндэслэн “Бакалаврын хөтөлбөр боловсруулах нэгдсэн журам”-ыг 2018 оны 9-р сарын 21-ний өдрийн эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн баталсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн хорооны ажлыг сайжруулах

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн хорооны үйл ажиллагаа, ажлын төлөвлөлт, тайланг тогтмолжуулах

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож, багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

Дараах байгууллагуудтай түншлэл, хамтын ажиллагааны гэрээтэй ажилладаг.

- Орхон аймгийн Боловсрол соёл урлагийн газар / БШУГ/
- Булган аймгийн Боловсрол соёл урлагийн газар / БШУГ/
- Орхон аймгийн цэцэрлэгүүд: 1,2,5,6,7,8,9,10,11,15,16,17,
- 20,21,22,24, Дэгдээхэй, Одод, Унага цэцэрлэг гэх мэт

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Түншлэгч байгууллагуудтай ахисан түвшний сургалтыг сайн зохион байгуулдаг

Анхаарах асуудал:

- Төгсөгчдийн холбооны ажил тогтмолжоогүй

Зөвлөмж:

- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааг сайжруулан, тогтмолжуулах

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- Нийт орлогын 81,4%-ийг хөтөлбөрийн хэрэгжилтэд зарцуулдаг, зээлгүй.
- Сүүлийн 5 жилд төрийн сангаас оюутны хөгжлийн зээл 9450000 төгрөг, буцалтгүй тусламжийн 66167040 төгрөгийн санхүүжилт авсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- Орлого зардлын тооцоог 1 оюутнаар тооцон гаргаагүй.

Зөвлөмж:

- Орлого, зарлагаа нарийн тооцох санхүүгийн мэргэжлийн хүн ажиллуулах

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Мэргэжлийн хомсдолын судалгаанд үндэслэн хөтөлбөрөө сайжруулж ажилладаг.
- Хөвсгөл, Булган, Орхон, Сэлэнгэ, Завхан аймгийн нийт 50 гаруй сургууль цэцэрлэгийн 1000 орчим багш ажилтанд сургалт зохион байгуулж мэргэжлийн хөтөлбөр болон сургуулиа сурталчилсан.
- 2018-2021 оны хичээлийн жилд нийт 60 гаруй багш боловсролын удирдах ажилтнууд ахисан түвшний сургалтыг дүүргэж магистрын дипломын ажлаа амжилттай хамгаалсан.
- Багш, сургуулийн өмнөх насны боловсрол хөтөлбөрөөр хөдөө орон нутгийн захиалга, багшийн хэрэгцээнд тулгуурлан орон нутаг, сургуулийн захиалгаар суралцаж, орон нутагтаа очиж ажилладаг.
- Мэргэжил сурталчлах өдөрлөгийг 2015 оноос эхлэн багш, оюутны бүтээлийн үзэсгэлэн, шилдэг хэрэглэгдэхүүн уралдаан, шилдэг эсээ шалгаруулах, эрдэмтний индэр лекц, тэнхимийн танилцуулга, гарын авлага хэлбэрээр зохион байгуулдаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**Онцлог зүйл/Туршлага:**

- Мэргэжил сурталчлах үйл ажиллагааг олон хэлбэрээр зохион байгуулдаг.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн идэвхжүүлэлтийн төлөвлөгөө, тайлан тогтмолжуулах.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн идэвхжүүлэлтийн төлөвлөгөө, тайланг үе шаттай хийж нэгтгэх

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- Сургуулийн үндсэн сайт <http://www.margad.mn>, “Маргад Кебир Оюутнууд” , “Маргад цахим багш нарын групп” зэрэг facebook группээр мэдээллийг нээлттэй хүргэдэг.
- Тэнхимийн багш нар <http://www.learning.margadedu.com/> буюу MOODLE цахим сургалтын системд өөрийн заадаг хичээлийн стандарт, хөтөлбөрийг байршуулсан бөгөөд багш бүр хичээлийг онлайн хэлбэрт оруулан вебдээ байрлуулсан.
- Жил бүр сургууль сурталчлах “Нээлттэй өдөрлөг” зохион байгуулж багш, сурагчдын бүтээлийн үзэсгэлэн гарган сургалтын хөтөлбөрөө сурталчилдаг.
- www.margad.mn вэбсайтад Сургалт>Бакалаврын хөтөлбөр> Багш-Бага ангийн боловсрол цэсэнд хөтөлбөрийн танилцуулга, зорилго, сургалтын арга зүй, сургалтын төлөвлөгөө, багшлах дадлагын удирдамж, гадаад хамтын ажиллагаа, төгсөлтийн баримт бичгийн талаар ил тод байршуулсан

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөр тус бүрийн зорилго, сургалтын арга зүй, сургалтын төлөвлөгөө, багшлах дадлагын удирдамж, гадаад хамтын ажиллагаа, төгсөлтийн баримт бичгийн мэдээллийг веб сайтдаа дэлгэрэнгүй оруулж өгсөн.

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

ШАЛГУУР 5. СУРАЛЦАГЧИД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Элсэгчид тавих шаардлага нь бакалаврын хөтөлбөрийн суралцахуйн зорилтот үр дүнд хүрэх боломжийг тооцсон, шударга, ил тод байна. Элсэгчийн ерөнхий эрдмийн шалгалтын оноо нь тухайн жилүүдийн тогтоосон босго оноогоор оюутан элсүүлдэг.
- Шалгалтын онооноос гадна хүүхдэд хайртай, багшлах хүсэл тэмүүлэлтэй байхыг элсэгчдийн тусгай шаардлагад асуулга хэлбэрээр оруулсан.
- “Маргад” дээд сургуулийн багш, сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуур
- “Маргад” дээд сургуулийн эрдмийн зөвлөлийн 2018 оны 09 сарын 21-ний тогтоол “Бакалаврын хөтөлбөр боловсруулах нэгдсэн журам”
- Маргад дээд сургуульд оюутан элсүүлэх журам (Захиргааны зөвлөлийн 2018.03.29-ны шийдвэр)

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Орон нутгийн болон бүс нутгийн элсэгчид олон

Анхаарах асуудал:

Элсэлтийн маркетинг, элсэгчдийг идэвхжүүлэхэд төгсөгчдөө татан оролцуулах

Зөвлөмж:

- Оюутны хөтөч цахим гарын авлагатай болох

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Оюутанд зөвлөн туслах үйлчилгээнд удирдлагын зүгээс хяналт тавин хэрэгжүүлж ажилладаг. Зөвлөх багш, хариуцсан ангийн оюутны төлөвшилд чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулдаг.

- “Маргад” дээд сургуулийн багш, сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуур
- Захиргааны зөвлөлийн 2018 оны 03 сарын 29 -ний хурлаар баталсан “Маргад” дээд сургуульд оюутан элсүүлэх журам”

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сэтгэл зүйн клуб ажиллуулж гэр бүлтэй оюутнуудад сэтгэл зүйн дэмжлэг үзүүлсэн.
- Мэргэжлийн сэтгэл зүйч ажилладаг.

Анхаарах асуудал:

- Зөвлөх багш, сургалтын туслах ажилтан, сургалтын менежер, арга зүйч, байрны багш, эмч, сэтгэл зүйч нарын үйлчилгээний чанарын үнэлгээ, сайжруулалтыг боловсронгуй болгох

Зөвлөмж:

- Шинэ элсэгчдэд зориулсан зөвлөн туслах оюутны хөтөч болох гарын авлагатай болох

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшуулал

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Оюутны эрэлт хэрэгцээнд суурилсан клуб, бүлгэм “Судлаач оюутан” клуб 2013 оюутны судалгааны чадварыг сайжруулах чиглэлээр зөвлөн тусалж ажиллаж эхэлсэн. Оюутны тоо нэмэгдсэнээр 2014-2015 оны хичээлийн жилээс клуб болон өргөжиж, оюутан суралцагчдын судалгаа, шинжилгээний ажил хийх мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх, судлаач оюутны тоог өсгөх, ярих илтгэх ур чадварыг нэмэгдүүлэх зорилготой.
- 2017-2018 Аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан илтгэлийн уралдаанд амжилттай оролцсон.
- 2018 - 2019 оны хичээлийн жилд Аймгийн “Хүүхэд гэр бүлийн хөгжлийн газар”- аас зохион байгуулсан илтгэлийн уралдаанд 6 оюутан оролцсон
- Эх орончдын өдөр зохион байгуулсан “Ардчилсан хувьсгалын үнэ цэн” уралдаанд СӨББ-2 ангийн оюутан Т.Анударь “Тусгай байр”
- Улсын хэмжээнд зохион байгуулсан “Монголын шашин соёл” сэдэвт илтгэлийн уралдаанд 3 оюутан оролцож Т.Анударь 2 -р байр
- Оюутны оролцооны клуб хөгжлийн төлөвлөгөө тайлан, мэдээлэл
- Оюутны санал асуулга, тэдэнтэй хийсэн ярилцсан ярилцлага

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Ажил олгогчид төгсгөгчид сэтгэл хангалуун
- Оюутнууд нийгмийн идэвх сайтай

Анхаарах асуудал:

- Клубүүдийн үйл ажиллагааг олон нийт рүү чиглүүлж нөлөөллийн ажлууд зохион байгуулах

Зөвлөмж:

- Орлоготой оюутан хөтөлбөр хэрэгжүүлэх.

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

- Шилжилт хөдөлгөөний судалгааг он оноор гаргаж харьцуулан дүгнэлт хийсэн.
- 2018 оноос элсэгчдийн шилжилт хөдөлгөөн буурсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад зориулсан нөхцөл байдлын судалгаанд үндэслэн орчны сайжруулалт хийгдэж байна.Тэдэнд төлбөрийн хөнгөлөлтийг сургуулийн захиргааны шийдвэрээр үзүүлж байна. “Багш, сургуулийн өмнөх насны боловсрол” мэргэжлээр хөгжлийн бэрхшээлтэй 2 оюутан төгсжээ.

Анхаарах асуудал:

- Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг дэмжих дүрэм, журмаа сайжруулах

Зөвлөмж:

- Оюутны шилжилт хөдөлгөөнтэй холбогдох дүрэм, журмыг сайжруулах

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- Мэргэжлийн боловсрол олгох хөтөлбөрийн заавал болон сонгон судлах хичээлүүдийг амжилттай судалж, 120-оос доошгүй кредит цуглуулсан, ахицын шалгалтаар хангалттай үнэлгээ авсан, мэргэжлийн тэнхим, профессорын багаас холбогдох дүрэм журмын хүрээнд тавьсан тусгай шаардлагуудыг биелүүлсэн.
- 1.7-оос доошгүй голч оноотой суралцагчид бакалаврын зэрэг олгодог. Хөтөлбөрийн алба оюутны бакалаврын зэрэг авахад заавал судлах ёстой модулиудтай холбоотой асуудлыг шийдвэрлэдэг ба хэрвээ оюутны сургалтын төлөвлөгөөнд өөрчлөлт орсон бол хөтөлбөрийн албаны дарга хянаж баталгаажуулдаг.
- Төгсөлтийн бичиг баримтыг БСШУСЯ-аас гаргасан эрх зүйн акт, “Сургалтын журам”, “Оюутны журам” болон бусад эрх зүйн бичиг баримтын дагуу олгодог

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Төгсөлтийн баримт бичиг нь кирилл, монгол бичгээр бичигдсэн.

Зөвлөмж:

- Англи хэлээр бичилттэй байх

V шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

ШАЛГУУР 6. БАГШЛАХ БҮРЭЛДЭХҮҮН

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

- Багш нарын 36% нь эрдмийн зэрэгтэй.
- Багш нар сургуулийн өмнөх боловсролын чиглэлээр орон нутагтаа үнэлэгдсэн туршлагатай.
- Үндсэн багш, цагийн багш, туслах багш ажилд авах журам /Удирдах зөвлөлийн 2018-03-29 тоот тогтоол/

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Мэргэжлийн арга зүйн чиглэлээр орон нутагтаа үнэлэгдсэн туршлагатай багштай.

Анхаарах асуудал:

- СӨБ-ын чиглэлээр эрдмийн зэрэгтэй багшгүй.

Зөвлөмж:

- Багш нараас СӨБ-ын чиглэлээр судалгааны ажил хийж, эрдмийн зэрэг хамгаалах

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

- 2017.03.24-ний өдөр батлагдсан Багшийн хөгжлийн хөтөлбөртэй.
- Дидактикийн тэнхимээс 2017 оноос багш Б.Дулсанням БНХАУ-ын Өвөрмонголын Багшийн их сургуулийн докторантурт, 2018 оноос англи хэлний багш И.Булган Тайванд тус тус, нийт 2 багш докторантурт суралцаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан.

Анхаарах асуудал:

- 2017.03.24 өдөр батлагдсан багшийн хөгжлийн хөтөлбөрийн хугацаа дууссан.

Зөвлөмж:

- Багшийн хөгжлийн хөтөлбөрийг үргэлжлүүлэн боловсруулж, хэрэгжүүлэх

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Багш, оюутны “Эрдэм шинжилгээний бичиг” 9 боть хэвлэсэн.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- Улсын хэмжээнд СӨБ-ын мэргэжлийн онол, арга зүйн чиглэлээр эшлэлгүй.

Зөвлөмж:

- Залуу багш нар сургалт, судалгааг хослуулан багшлах арга барилд туршлагажих

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

- Маргад дээд сургуулийн багш нарын ажлыг үнэлэх дүгнэх журам журам /Удирдах зөвлөлийн 2018-03-29 тоот тогтоол/
- “Маргад” дээд сургуулийн багш нарын сургалтын ажлыг кредитээр үнэлэх журам /Удирдах зөвлөлийн 2018-03-29 тоот тогтоол/
- Багш нар жил бүр өөрийн үнэлгээний тайлан бичиж, хэлэлцүүлдэг

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага: байхгүй

Анхаарах асуудал:

- Багшийн сургалтын цагийн ачааллын судалгаа хийж, ачаалалд үнэлгээ өгөөгүй.

Зөвлөмж:

- Багш нарын сургалтын цагийн ачааллыг судалж, түүний дагуу эрдэм шинжилгээний ажил хийх бодит боломжийг нэмэгдүүлэх

VI шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

ШАЛГУУР 7. ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ, БАТАЛГААЖИЛТ

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

- Захирлын 2018 оны тушаалаар батлагдсан чанарын дотоод баталгаажуулалтын хөтөлбөртэй.
- Чанарын баталгаажуулалтын чиглэлээр багш нарт 3 удаа сургалт зохион байгуулсан.
- Чанарын дотоод баталгаажуулалтын удирдлага, зохион байгуулалтын схем
- Чанарын дотоод баталгаажуулалтын талаар оролцогч, сонирхогч талуудын оролцог хангах чиглэлээр хийсэн ажлын баримт (хяналт шалгалт хийсэн тухай баримт, сэтгэл хянамжийн судалгаа)

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийг оюутны хэрэгцээнд зориулан хэвлүүлсэн бөгөөд 2 удаа сайжруулсан.

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.

Илрэл нотолгоо:

- Төгсөгчдийн 84% мэргэжлийн, 12,2%, өөр ажил хийдэг, 2.6% суралцаж, ажилгүй 3,1% байна. Үүнээс 84% мэргэжлийн ажил эрхэлж байгаа нь харьцангуй өндөр үзүүлэлт юм.
- Оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгаа (ажил олгогч, төгсөгч, мэргэжлийн холбоо) тогтмол авдаг.
- Төгсөгчид мэргэжлийн салбарт хүлээн зөвшөөрөгдөж буйг нотлох баримт – Улсын 2014-15 оны хичээлийн жилд Уянга улсад II Байр, 2015-2016 онд 4 байр, 2016-2017 онд Рагчаа СХУ улсад II Байр, Багахангай шилдэг илтгэл Д.Отгонбаяр, 2019-2020 Увс аймагт II Байр, 2020-2021 Цэрэндулам цэцэрлэгт I Байр тус тус эзэлсэн.
- Мэргэжлийн холбоодтой хамтран ажиллаж буй байдал түшиц цэцэрлэгүүдтэй ур чадварын уралдаан 2, сурган хүмүүжүүлэх уншлага төгсөгчдийн дунд зохион байгуулдаг.
- 10 төгсөгч магистрт суралцаж төгссөн, одоо суралцаж буй 8 байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Төгсөгчид багш бэлтгэх бусад сургуулийн багш нартай эн зэрэгцэн ажиллаж, багшлах ур чадварын уралдаанд тэргүүлдэг. Харьцангуй цөөн оюутантай учраас багш нар оюутан бүрд хүрч ажиллах бүрэн боломжтой.

Зөвлөмж: Төгсөгчдийн ажлын байр хүлээх хугацааны судалгаа хийх

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Байгууллагын магадлан итгэмжлэл 2007, 2013, 2020 онд тус тус 3 удаа хийлгэсэн.
- Төгсөгчдөөс Орхон 1. Булган 2, нийт 3 эрхлэгч, арга зүйч 10, багийн засаг дарга 1, нийт 14 төгсөгч карьер ахисан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**Онцлог зүйл/Туршлага:**

- Төгсөгчид орон нутгийн цэцэрлэгүүдэд амжилттай багшилдаг.

Анхаарах асуудал: Төгсөгчдөөс мэргэжлээрээ ахисан түвшинд гадаадын ИДС-д суралцаж буй тохиолдол байхгүй.

Зөвлөмж:

- Төгсөгчдөөс мэргэжлийн чиглэлээр ахисан түвшинд гадаадын ИДС-иудад сургах талаар анхаарах

VII шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**ДҮГНЭЛТ**

Шалгуур		Бүрэн хангаса	Хэсэгчлэн хангаса	Хангаагүй 0	Үндэслэл, шалтгаан
1.	Хөтөлбөрийн төлөвлөлт	+			Хөтөлбөрөөр эзэмших суралцахуйн үрдүнг оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагыг тусган боловсруулж, 2015, 2019, 2020 онд сайжруулсан.
2.	Сургалтын үйл ажиллагаа	+			Хөтөлбөрийн агуулга нь СӨНХ-ийн хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцэх мэдлэг, дадал чадвар эзэмшихэд чиглэсэн. Хичээлийг аудио, видео, цахим хэлэлцүүлэг зэрэг хэлбэрээр боловсруулж Moodle болон Zoom програмаар оюутанд хүргэдэг. 30 кредит тутамд гарааны багшийн мэдлэг, чадвар хандлагыг прогресс тестийн системээр ахицыг үнэлдэг.
3.	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөөц	+			Хичээлийн зориулалтын байр, http://learning.margadedu.com сэтгэхүй хөгжүүлэх МА оньсон, хөлөгт тоглоом үйлдвэрлэн цэцэрлэгүүдэд нийлүүлдэг. Оюутнууд дадлагын хугацаанд биет үзүүлэн хийдэг. Мэргэжлийн номын хангамж сайжирч байна. Хотхоноор хөгжүүлэх төлөвлөгөөтэй.

4.	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	+			Хөтөлбөрийн хорооны үндсэн чиглэл, ажиллах журиыг батлан мөрдөж байна. Түнш байгууллагуудтай сайн хамтран ажилладаг. Нийт төвлөрүүлсэн орлогын 81,4%-ийг хөтөлбөрийн хэрэгжилтэд зарцуулдаг, зээлгүй.
5.	Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ	+			Оюутан элсүүлэн суралцуулах болон төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх журам цалинтай оюутан хөтөлбөр, судлаач оюутан клубт хамрагдаж, орон нутгийн уралдаан, тэмцээнд оролцож, шагналт байрыг удаа дараа эзэлсэн.
6.	Багшийн үйл ажиллагаа	+			Сургуулийн өмнөх боловсролын чиглэлээр орон нутагтаа үнэлэгдсэн туршлагатай. Багш, оюутны “Эрдэм шинжилгээний бичиг” 9 боть бүтээл хэвлэгдсэн.
7.	Чанарын үнэлгээ, баталгаажилт	+			Чанарын дотоод баталгаажуулалтын хөтөлбөр, удирдлага, зохион байгуулалтын схемтэй. Төгсөгчдийн 84% мэргэжлийн ажил эрхэлж, тэднээс улсын уралдаанд 2, 4 тусгай, аймгийн уралдаанд II байр эзэлсэн. Төгсөгчдөөс 24 хүн карьер ахиж, удирдах ажил эрхэлж байна.
Дүгнэлт		БҮРЭН ХАНГАСАН			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Маргад дээд сургуулийн “Сургуулийн өмнөх боловсролын багш” бакалаврын хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Боловсролын чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагч: Ч.Байгалмаа

Шинжээчийн багийн гишүүн: .Б.Түвшинжаргал

Шинжээчийн багийн гишүүн: Б.Наранчимэг

НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

Сургуулийн нэр	МАРГАД ДЭЭД СУРГУУЛЬ
Хөтөлбөрийн нэр	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАГШ
Хөтөлбөрийн индекс	D011201
ЗӨВЛӨМЖ	
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> • Дидактикийн хөтөлбөрийн агуулгыг интеграцчилах боломжийг судлан хэрэгжүүлэх • Шинэ зууны иргэдтэй ажиллах “Сургуулийн өмнөх боловсролын багш”-д тавигдах шаардлагад нийцүүлэх
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> • Хөрвөх ангиар суралцах оюутны дүйцүүлэх хичээлийн агуулгын давхцал, ялгааг сайтар тооцож дүйцүүлэх
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөөц	<ul style="list-style-type: none"> • Сургалтын хэрэглэгдэхүүнийг бүртгэлжүүлэх • Номын санд СӨББ хөтөлбөрийн номын баяжилтыг тусад нь гаргах
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	<ul style="list-style-type: none"> • Хөтөлбөрийн хорооны үйл ажиллагаа, ажлын төлөвлөлт, тайланг тогтмолжуулах • Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааг сайжруулан, тогтмолжуулах • Орлого, зарлагаа нарийн тооцох санхүүгийн мэргэжлийн хүн ажиллуулах • Вэб сайтад хөтөлбөрийн тухай мэдээллээ тухай бүр тогтмол шинэчлэх
Шалгуур 5. Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> • Оюутны хөтөч цахим гарын авлагатай байх • Оюутны шилжилт хөдөлгөөнтэй холбогдох асуудлыг зохицуулах журмыг сайжруулах
Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> • Туршлагатай багш нарын залгамж халаа залуу багш нарыг чадавхжуулах • Мэргэжлийн хөгжлийн хувийн төлөвлөлтийн үйл явцыг сайжруулах • Залуу багш нар сургалт, судалгааг хослуулан багшлах арга барилд туршлагажих • Багш нарын сургалтын цагийн ачааллыг судалж, түүний дагуу эрдэм шинжилгээний ажил хийх бодит боломжийг нэмэгдүүлэх • Багш нар докторантурт элсэн суралцаж, эрдмийн зэрэг хамгаалахад анхаарах
Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт	<ul style="list-style-type: none"> • Төгсөгчдийн ажлын байр хүлээх хугацааны судалгаа хийх хэрэгтэй.

- Төгсөгчдөөс мэргэжлийн чиглэлээр ахисан түвшинд гадаадын ИДС-уудад сургах талаар анхаарах

IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

№	Нэр	Албан тушаал	Зэрэг цол	Ажилласан жил	Заадаг хичээл
1.	Ц.Уранцэцэг	Тэнхимийн эрхлэгч	Доктор, дэд проф	38/7	Сурган хүмүүжүүлэх зүй. Бага насны СХЗ
2.	Н.Цэдэвсүрэн	Багш	Доктор, проф	43/5	СӨБ-ын дидактикийн хичээлүүд
3.	М.Байгальмаа	Багш	Магистр	28 / 2	СӨБ-ын дидактикийн хичээлүүд
4.	С.Хаш-Эрдэнэ	Багш	Доктор, проф	36/12	Сэтгэлгээний түүх соёл
5.	Н.Лхамхүү	Багш	Магистр	26/ 1	Цахим сургалтын арга зүй мэдээлэл зүй
6.	Б.Мөнхтуяа	Багш	Магистр	28/ 2	Хөгжмийн дидактик
7.	Л.Ариунжаргал	Багш	Магистр	13/ 8	ОЦМХ, найруулга зүй үгсийн сан
8.	Э.Тунгалагтамир	Мэргэжилтэн	Магистр	2/ 1	Англи хэл
9.	Д. Уранчимэг	Багш	Магистр	10/ 7	Монгол бичиг, Эхийн найруулга зүй Хүүхдийн уран зохиол

II. Оюутны нэрс

№	Оюутны нэрс	Курс	Сонгосон байдал
			Орон нутгийн, гадаад, дотуур байранд амьдардаг г.м
1.	А.Жаргалмаа	II	Өдрөөр суралцдаг, оюутны зөвлөлийн дарга
2.	Б.Гантуяа	II	Өдрөөр суралцдаг, дотуур байранд амьдардаг
3.	Х.Гантуяа	III	Өдрөөр суралцдаг, Увс аймгаас элсэгч
4.	Б.Нансалмаа	IV	Өдрөөр суралцдаг, Булган аймгаас элсэгч
5.	Б.Оюунсүвд	IV	Өдрөөр суралцдаг, дотуур байранд
6.	Р.Энхтуяа	IV	Орхон аймаг, хөрвөх сургалт

7.	Д.Мөнхзул	IV	Орхон аймаг, хөрвөх сургалт
8.	Б.Нэргүй	III	Орхон аймаг, хөрвөх сургалт
9.	М.Одонтуяа	III	Орхон аймаг, хөрвөх сургалт
10.	Б.Эрдэнэтуяа	III	МУБИС-ийн Багшийн сургуулиас ирсэн
11.	Ц.Нямжаргал	IV	Хөвсгөл аймгаас элсэгч
12.	Б.Баянжаргал	IV	Улаанбаатар хотоос суралцагч

III. Ажил олгогчдын нэрс

№	Овог нэрс	Байгууллага	Албан тушаал
1.	Ц.Дэнсмаа	Орхон 8-р цэцэрлэг	эрхлэгч
2.	Л.Алтанзул	Орхон 5-р цэцэрлэг	эрхлэгч
3.	Х.Сансартуяа	Орхон 9-р цэцэрлэг	эрхлэгч
4.	Амгалан	Булган, Хялганат	эрхлэгч
5.	Д.Эрдэнэчимэг	Орхон 11-р цэцэрлэг	эрхлэгч
6.	Г.Туяа	Булган 2-р цэцэрлэг	эрхлэгч
7.	С.Бүрэнцэцэг	Орхон 27-р цэцэрлэг	эрхлэгч
8.	С.Сэлэнгэбүтэдмаа	Хөөрхөн гүнж цэцэрлэг	эрхлэгч
9.	Б.Энхцэцэг	Одод цэцэрлэг	эрхлэгч
10.	Ц.Мягмарцэнд	Булган 7-р цэцэрлэг	эрхлэгч
11.	Д.Дашням	Орхон БШУГ	ахлах мэргэжилтэн

IV. Төгсөгчдийн нэрс

№	Овог нэрс	Төгссөн он	Байгууллага	Албан тушаал
1.	Х.Уянга	2020	Орхон 9-р цэцэрлэг	багш
2.	М.Цэрэндулам	2017	Орхон 9-р цэцэрлэг	багш
3.	И.Жавзандулам	2021	Орхон 9-р цэцэрлэг	багш
4.	Т.Энхцэцэг	2022	Одод цэцэрлэг	багш
5.	В.Одонцэцэг	2017	Одод цэцэрлэг	багш
6.	Ц.Дэлгэрсайхан	2018	5-р цэцэрлэг,	багш
7.	Б.Анхцэцэг	2016	5-р цэцэрлэг,	багш
8.	Ч.Отгон	2018	8-р цэцэрлэг,	багш
9.	Т.Анударь	2021	8-р цэцэрлэг,	багш
10.	Б.Амгалан	2017	Булган Хялганат цэцэрлэг	багш

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал
/албан бичгийг оруулах/



“МАРГАД” ДЭЭД СУРГУУЛЬ

61000 Эрдэнэт, Орхон аймаг, Уурхайчин баг
Утас/Факс: 7035-7399

2022.06.18 № 1/19

танай _____-ны _____

**БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН ИТГЭМЛЭХ
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛД**

Шинжээчийн багийн тайлан хүлээн авсан тухай

“Маргад” дээд сургуулийн “Багш, бага ангийн боловсрол” /D011301/ мэргэжлийн хөтөлбөр болон “Багш, сургуулийн өмнөх боловсрол” /D011201/ мэргэжлийн хөтөлбөрт шинжээчийн баг хөндлөнгийн үнэлгээ хийсэн зөвлөмж, дүгнэлтийг хүлээж авлаа.

Цаашид дээрх хөтөлбөрүүдэд хөндлөнгийн үнэлгээ хийсэн шинжээчдийн багийн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах болно.

ЗАХИРАЛ



/Доктор, профессор
Ц.Эрдэнэчулуун/

ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо)

[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/

ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо)

[Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/